№9

БНМАУ

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

# ЗАХИРАМЖ

1992 оны 12 сарын 17 өдөр

Дугаар № 83

Улаанбаатар хот

Нийслэлийн худалдаа, нийтийн
хоолны "Улаанбаатар импэкс"
компани /УИГ/ байгуулах тухай

1.Хотын худалдаа, хоолны ерөнхий компанийг одоогийн материаллаг баазад нь тулгуурлан "нийслэлийн худалдаа, нийтийн хоолны Улаанбаатар-импэкс" компани /УИГ/ болгон өргөн хэрэглээний барааны бирж, валютын дэлгүүртэйгээр байгуулсугай.

2."Улаанбаатар импэкс" компани /УИГ/-ийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

3.Нийслэлийн худалдаа, нийтийн хоолны Улаанбаатар импэкс компанийн ерөнхий захирлаар Ж.Октябрийг томилсугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны 226 дугаар тогтоол болон мөн оны 246 дугаар тогтоолоор баталсан Худалдаа, хоолны ерөнхий компанийн дүрмийг хүчингүйд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ
ДАРГА Ц.БААСАНЖАВ

Нийслэлийн Засаг даргын 1992 оны
№83 тоот захирамжийн хавсралт.

# НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАА, НИЙТИЙН ХООЛНЫ УЛААНБААТАР ИМПЭКС КОМПАНИЙН ДҮРЭМ /ҮҮГ/

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.Нийслэлийн худалдаа, нийтийн хоолны "Улаанбаатар импэкс" компани нь /цаашид компани гэх/ нийслэл хотын хүн амын хүнс, өргөн хэрэглээний барааны хангамжийн эх үүсвэрийг гэрээ, хэлцлийн үндсэн дээр үйлдвэрлэгч, бэлтгэн нийлүүлэгчээс бүрдүүлэх, төвлөрсөн журмаар хуваарилсан барааг зохих хуваарийн дагуу худалдаа, нийтийн хоолны аж ахуйн нэгж, бусад хэрэглэгчдэд хүргэх, өргөн хэрэглээний барааны биржийн худалдаа эрхлэх, зарим барааны нөөц бий болгох, улсын захиалга, даалгавраас нийслэлд төвлөрүүлсэн болон бие даан олсон экспортын санг гадагш гаргаж оронд нь өргөн хэрэглээний бараа импортлох чиглэлээр гадаад худалдааны үйл ажиллагаа явуулах үндсэн үүрэгтэй улсын үйлдвэрийн газар мөн.

2.Компани нь үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

3.Компани нь Монгол улсын аж ахуйн нэгжийн тухай хуулийн дагуу өөрийгөө удирдах, төлөвлөх, хөгжүүлэх, санхүүжүүлэх зарчим дээр ажиллана. Компанийн эд хөрөнгө нь эргэлтийн хөрөнгө, санхүүгийн бусад нөөцөөс бүрдэнэ. Компани нь хөрөнгөө Монгол улсын хууль тогтоомж, энэхүү дүрэмд заасан үйл ажиллагааны чиглэлийн дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах бөгөөд бие даасан тайлан тэнцэл гаргадаг, банкинд дотоод, гадаад гүйлгээний харилцах данстай байна.

4.Компани нь өөрийн таних тэмдэгтэй байх бөгөөд зохих журмаар хийлгэсэн тэмдэг, тушаал, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ. Компани хөдөлмөрийн дотоод журмыг хамт олны хурлаар баталж мөрдөнө. Компанийг Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр өөрчлөх буюу татан буулгана.

## Хоёр. Компанийн үүрэг

5.Компани нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ.

а/Хүн амын эрэлт хэрэгцээ, барааны хангамж, борлуулалтын байдалд судалгаа хийсний үндсэн дээр нийслэлийн хүн амын гол нэ-

рийн хүнс, өргөн хэрэглээний барааны хэрэгцээг нарийвчлан тооцож, улсын захиалга, даалгаварт тусгуулах, зах зээлийг төлөвлөх;

б/Хүнс, өргөн хэрэглээний барааны хангамжийн эх үүсвэрийг гэрээ, хэлцлийн үндсэн дээр өмчийн бүх хэвшлийн үйлдвэр, бэлтгэн нийлүүлэгч, импортоос бүрдүүлэх;

в/Харилцан ашигтай худалдаа, бараа солилцоо хийх, хамтарч ажиллах замаар гадаад худалдааны бие даасан үйл ажиллагаа явуулах;

г/Төвлөрсөн журмаар хуваарилсан барааг зохих хуваарийн дагуу өмчийн бүх хэвшлийн худалдаа, нийтийн хоолны аж ахуйн нэгж, бусад хэрэглэгчдэд бөөнөөр худалдаалах ажлыг завсрын шат дамжлагагүйгээр зохион байгуулах;

д/Төв, орон нутгийн худалдаа, үйлдвэрийн улсын ба хувийн компани, хоршоо, дотоод гадаадын бие даасан худалдаачидтай байнгын холбоо тогтоох замаар барааны хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

е/Зарим нэрийн хүнс, өргөн хэрэглээний барааг биржээр дамжуулан худалдах, энэ зорилгоор өөрийн бүрэлдэхүүн дэх биржийг зөв зохион байгуулж, биржийн худалдааны олон хэлбэрийг ашиглах;

ё/Зах зээл дэх барааны хангамж, шинэ нэрийн бараа, дотоод гадаад зах зээлийн байдлын талаар нийслэлийн хүн ам, өмчийн бүх хэвшлийн худалдааны байгууллага, нэгжүүдийг тодорхой мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;

ж/Гадаадын байгууллагуудтай хамтарч ажиллахад нь өмчийн бүх хэвшлийн худалдаа, нийтийн хоолны газар, жижиг үйлдвэрлэл /өргөн хэрэглээний болон хүнсний бараа үйлдвэрлэх чиглэлээр ажилладаг/ эрхлэгчдэд туслалцаа үзүүлж, тэдгээрийн хооронд зуучлах;

з/Нийслэл хотын нутаг дэвсгэр дээр оршдог өмчийн бүх хэвшлийн худалдаа, хоолны аж ахуйн нэгжүүдийн ажилтан, ажилчдын зах зээлийн мэдлэгийг дээшлүүлэх, мэргэжлийн сургалт явуулах

ажлыг холбогдох байгууллагатай хамтран буюу бие даан зохион байгуулах;

и/Компанийхаа үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлыг дэс даралтай шийдвэрлэж байх;

6.Компани нь дор дурдсан эрх эдэлнэ

а/Монгол улсын хууль тогтоомжийн дагуу аж ахуйн болон гадаад эдийн засгийн үйл ажиллагааг бие даан явуулах;

б/Өөрийн бүрэлдэхүүнд аж ахуйн дотоод тооцооны үндсэн дээр ажиллах жижиг үйлдвэр, агуулах, валютын дэлгүүр, түүнчлэн гадаад орон, бусад аймаг хоттой хамтарсан үйлдвэр байгуулах, гадаад дотоодод өөрийн төлөөлөгчийг явуулах;

в/Улсын стандарт, техникийн нөхцөл, чанар, үнэ гэрээний шаардлага хангаагүй, хэрэглэгчийн эрх ашигт хохироосон бараа, бүтээгдэхүүнийг хүлээн авах, худалдаалах, үнийг төлөхөөс татгалзах;

г/Хүнс, өргөн хэрэглээний барааны хангамж, чанар үнийн талаар нийслэл хотын хэмжээнд олон нийтийн санал, бодлыг судлаж дүгнэлт хийх, хүн ард иргэдэд ил тод мэдээлэх;

д/Хэрэглэгчийн болон компанийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон асуудлыг зохих шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

е/Компанийн аж ахуйн үйл ажиллагааны үр дүнтэй холбож орон тоо, ажилтан, ажилчдынхаа цалин, шагнал, урамшууллын хэмжээг хамт олны саналыг үндэслэн тогтоож, бүх нийгмийн асуудлыг шийдвэрлэх;

ГУРАВ. <u>КОМПАНИЙН УДИРДЛАГА</u>

7.Компанийг нийслэлийн Засаг дарга томилсон ерөнхий захирал толгойлж, компанийн зорилт үүргийг хэрэгжүүлж ажлаа тайлагнана.

8.Компанийн ерөнхий захирал нь эрх хэмжээнийхээ асуудлаар Монгол улсын хууль тогтоомжийг нийцүүлэн тушаал гаргах, биелэлтийг зохион байгуулна.

9.Ерөнхий захирал нь дор дурдсан эрх эдэлж үүрэг хүлээнэ.

а/Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

б/Компанид хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчидтай компанийг төлөөлөн гэрээ байгуулна,

в/Компанийн нэрийн өмнөөс гэрээ, хэлцэл байгуулж компанийн хууль ёсны эрх ашгийг хамгаална,

г/Компанийн хэтийн төлөв, бодлого, чиглэл, үйл ажиллагааны талаарх асуудлаар санал боловсруулж захирлын зөвлөл, холбогдох дээд шатны байгууллагад оруулж хэлэлцүүлнэ,

д/Компанийн эд хөрөнгийг захиран зарцуулна,

е/Ерөнхий захирал итгэмжлэхгүйгээр компанийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах эрхтэй.

10.Компанийн ерөнхий захирал ажлын аппараттай байхын зэрэгцээ асуудлыг шуурхай шийдвэрлэхэд туслах зөвлөх үүрэгтэй захирлын зөвлөлтэй байна. Энэхүү зөвлөлийн ажиллах журмыг ерөнхий захирал тогтооно.